



УУЛ УУРХАЙ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Профессор Ч. Хашчулуун

Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн

Удиртгал

- Уул уурхайн салбарын тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөө:
 - 1-р үйл явдал (2006): Уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн эхлэл
 - 2-р үйл явдал (2009): Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, олон улсын санхүүгийн зах зээлд нэвтрэв.
 - Төсвийн нэгдмэл байдал (Fiscal integration)
 - Хөгжлийн төлөвлөлтийн систем
 - Санхүүгийн системийн шинэчлэл
 - Үнэт цаасны зах зээл
 - PPP систем
 - Төсөв
 - 3-р үйл явдал (2016-): “Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” батлав.

Удиртгал

- Байгаль орчин, хөгжлийн олон улсын хүрээлэн(IIED)-ийн дагуу, тогтвортой байдлыг хангахад оруулах хувь нэмрийг дараах хүрээнд авч үзлээ. Үүнд:
 - Эдийн засаг
 - Макро эдийн засгийн нөлөө
 - Гадаад худалдааны нөлөө
 - Улсын төсөвт үзүүлэх нөлөө
 - Нийгэм
 - Байгаль орчин
 - Засаглал
 - Бодлогын хүрээ
 - Компанийн засаглал

2. Эдийн засаг

2.1. Бүтцийн өөрчлөлт, ДНБ-д эзлэх хувь

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Хөдөө аж ахуй	19.2	17.9	11.7	10.3	11.3	13.4	13.3	13.4	11.7	10.3	10.8
Уул уурхай олборлолт	20.2	19.5	21.5	19.3	16.4	14.9	16.5	17.1	20.1	23.5	23.5
Боловсруулах үйлдвэрлэл	8.8	9.2	9.1	9.0	9.3	10.5	10.6	9.7	9.8	11.2	11.6
Барилга	1.9	1.3	2.6	3.1	5.0	5.1	4.4	4.2	4.0	3.7	3.6
Худалдаа үйлчилгээ	39.7	43.1	44.8	45.8	46.9	44.7	45.8	47.5	46.1	42.3	39.6

Эх сурвалж: YCX

2.2. Уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөө

Уул уурхайн салбар (ДНБ-д эзлэх %)



Эх сурвалж: ҮСХ, судлаачдын тооцоолол

Уул уурхайн орлого (төсөвт эзлэх %)




Эх сурвалж: Сангийн яам

Уул уурхайтай холбоотой ажил эрхлэлт (нийт ажил эрхлэлтэд эзлэх %)



Эх сурвалж: ҮСХ, судлаачдын тооцоолол


Уул уурхайн экспорт (нийт экспортод эзлэх %)



Эх сурвалж: ГЕГ


2.3. Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт

Гадаад худалдаа, нийт эргэлт, экспорт, импорт, тэрбум ам.доллар



Эх сурвалж: YCX

Нийт хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг



Эх сурвалж: YCX

2.4. Баялгийг удирдах, хуваарилах

- Уул уурхайгаас олсон орлогыг орон нутаг болон засгийн газарт хуваарилах
 - Орон нутаг - засаглал сул
 - Засгийн газар - Хүнд суртал, орон нутгийн хэрэгцээний талаарх мэдээлэл хомс
- Монгол Улсын төсвийн орлогын зарим хэсгийг орон нутгийн засаг захиргаанд хуваарилах
 - Үл хөдлөх хөрөнгө, газрын татвар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензийн зарим төлбөр орон нутагт үлддэг.
 - 2011 онд байгуулагдсан **Орон нутгийн хөгжлийн сангаар** дамжуулан уул уурхайн салбарын орлогыг засгийн газраас орон нутагт хуваарилдаг.
- Уул уурхайн компаниудын орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө
 - 2017 онд уул уурхайн компаниудаас 30 тэрбум төгрөг хандивласан.
Ботсвана- Дебсвана, Монгол улс - Говь Оюу хөгжлийг дэмжих сан (ОТ ХХК), Хөшөөт хөгжлийн сан (Моненко ХХК)
- Уул уурхайн дараах үе шат
 - Баялгийн сан, Норвеги, Чили, Саудын Араби
 - Монгол улс- Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сан

3. Нийгэм

3.1. Бичил уурхай

- Бичил уурхай: технологи, машин техник бараг ашиглахгүй үйл ажиллагаа явуулдаг албан бус уул уурхай (бичил уурхай эрхлэгчдийн 70-80% нь албан бус)
- Дэлхий дээр 30 гаруй ашигт малтмалын түүхий эд олборлож буй 30 сая бичил уурхай эрхлэгчид байдаг.
 - Үүний 10-15 сая нь гар аргаар алт олборлогчид
- Бичил уурхай эрхлэгчид нь бүс нутгийн иргэдийн орлогын томоохон эх үүсвэр юм. Гэхдээ энэ нь хүрээлэн буй орчныг доройтуулж, эрүүл ахуй, аюулгүй байдлын таагүй нөхцөлийг бүрдүүлэн, газар тариалан, хүнсний үйлдвэрлэлд нөлөөлж, гол мөрнийг бохирдуулдаг.
- Гар аргаар алт олборлогчид: алт олборлох үйл явцад мөнгөн үс ашигладаг.
- Эдгээр асуудлыг шийдвэрлэх дэвшилтэт алхам: **албан ёсны болгох** (Бичил уурхай зэрэг албан бус орлого олох үйл ажиллагааг хууль эрх зүйн зохицуулалт, бодлогоор дамжуулан албан ёсны болгох)
 - ОУИТБС-ын (EITI) тайланд бичил уурхайн салбарын мэдээллийг оруулах шаардлагатай.
- 2016 онд хийгдсэн судалгааны дагуу, Монгол улсад 100,000 орчим бичил уурхай эрхлэгчид байдаг.
 - Монгол Улс бичил уурхайг албан ёсны болгов: “Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох журам” (2010)-ыг баталсан, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтарсан “Тогтвортой бичил уурхай” төслийг хэрэгжүүлсэн.

3.2. Олон нийтийн эрүүл мэнд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)

- Уул уурхайгаас үүдэлтэй эрүүл мэндийн асуудалд ХАБЭА-аас гадна хүрээлэн буй орчин, иргэдийн эрүүл мэнд багтдаг.
- Тэсэлгээ, олборлолт, малтлага зэрэг төслийн үйл ажиллагааны явцад ажиллагсад аюул осолд өртдөг.
 - ОУХБ (ILO) нь уул уурхайн салбарын ХАБЭА-тай холбоотой олон улсын 10 стандарт, 9 практик дүрэмтэй
- Австрали нь ХАБЭА-н хамгийн сайн туршлагатай орон: Засгийн газар болон аж үйлдвэрүүд эрсдэлийн менежментээр дамжуулан “хохиролгүй” үйл ажиллагаа явуулах тал дээр хамтран ажилладаг.
- Монгол Улс ОУХБ-ын стандартыг мөрддөг ч хэрэгжилт хангалтгүй байна.


Хүснэгт. Үйлдвэрлэлийн осолд өртсөн ажиллагсад, үйл ажиллагааны салбараар

	2016	2017	2018	2019-Н1
Уул уурхай олборлолт	61	55	73	30
Боловсруулах үйлдвэрлэл	32	62	26	11
Барилга	21	15	17	12
Тээвэр агуулах	19	21	27	13
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	43	36	34	7
Бусад	156	143	106	63
Нийт	332	332	283	136

Эх сурвалж: YCX

3.3. Боловсрол

Мэргэшсэн ажилтны дутагдалтай байдал нь төслийн явц удаашрах, зардал нэмэгдэх, орон нутгийн иргэдийг заасан хэмжээнд ажлын байраар хангахад саад учрах зэрэг асуудал үүсгэдэг.




- Оюу толгой төслийн боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалт 173 сая\$
- Үүний, МСҮТ - 78.7 сая \$
 - Сургуулийн барилга– 27 сая \$
 - Тоног төхөөрөмж– 3.9 сая \$
 - 3300 хөтөлбөр – 36 сая \$
 - Дагалдан суралцах хөтөлбөр– 3.5 сая \$
 - МСҮТ-ийн багш нарын сургалт– 5.4 сая \$
 - Шинээр төгсөгчийн хөтөлбөр – 210.000 \$
 - Дадлагажигчийн хөтөлбөр – 1.2 сая \$
 - Түршилтын хөтөлбөр– 20.000 \$
 - 3D хөтөлбөр– 1.5 сая \$
 - Чадавхыг хөгжүүлэх хөтөлбөр– 50.000 \$

4. Байгаль орчин

Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөө

- Байгаль орчны асуудлыг хайхрахгүй орхисноор ихээхэн сөрөг үр дагаварт хүрдэг.
 - Байгалын нөөц
 - Хөрсний элэгдэл, доройтол
 - Усны бохирдол
 - Агаарын бохирдол
 - Эдийн засгийн нөөц
 - Бусад салбарын хувьд байгалийн нөөц үйлдвэрлэлийн чухал хүчин зүйл юм. Байгалийн нөөц буурах нь бусад салбарын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлнө.
 - Ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлт буурах
 - Ашигт малтмалын үйлдвэрлэлийн нийгмийн капитал
 - Нэр хүндийн эрсдэл
 - Завсрын хэрэглээ болон эрчим хүчний зардлын өсөлтөөс шууд бус эрсдэл үүснэ.

4.1. Уул уурхайн салбарын нийлүүлэлтийн сүлжээ ба байгаль орчин



• Хайгуулын үе шат

- Тойм судалгаа нь хайгуулын тусгай зөвшөөрөл шаарддаггүй боловч ургамлыг өрөмдөх, ухах зэргээр гэмтээхийг хориглодог.
- Хэрэв хайгуул нь улсын төсвөөс санхүүжиж байгаа бол тусгай зөвшөөрөл шаардлагагүй.
- Доорх тохиолдлуудад хайгуул хийхийг хориглоно. Үүнд:
 - Улсын тусгай хамгаалалттай газар
 - Гол мөрний эх, усан сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар
 - Харин ашигт малтмалын орд нь стратегийн ач холбогдолтой бол эдгээр тусгай бүсэд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг.

4.1. Уул уурхайн салбарын нийлүүлэлтийн сүлжээ ба байгаль орчин

- Бүтээн байгуулалтын үе шат
 - ТЭЗҮ
 - Үйлдвэрлэлийн нарийвчилсан төлөвлөгөө, хүдэр болон хаягдал чулуулгийн хэмжээ, төслийн бусад үйл ажиллагааны төлөвлөгөө
 - Байгаль очинд үзүүлэх нөлөөлөл, менежментийн төлөвлөгөө, уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулна.
 - Талбайн бэлтгэл, цэвэрлэгээ
 - Ургамлыг цэвэрлэх
 - Ажилчдын суурьших бүсийг бэлтгэх
 - Замын бүтээн байгуулалт
 - Ургамал ба амьтдын хоорондох байгалийн уялдаа холбоонд саад учруулдаг.
 - Ухаа-Худаг-Гашуун сүхайд чиглэлийн нүүрс тээвэрлэх зам нь зэрлэг ан амьтад олноор суурьшдаг газар болон улсын тусгай хамгаалалтын бүсээр дамжин өнгөрдөг.

4.1. Уул уурхайн салбарын нийлүүлэлтийн сүлжээ ба байгаль орчин

- Уул уурхайн үйл ажиллагаа

- Уурхайн хог хаягдал (илүүдэл хүдэр, хаягдал чулуулаг, хог хаягдал болон нуруулдан уусгахад зарцуулсан хүдэр)
 - Хүдрийн олборлолт боловсруулалтаас үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн дүрэм(2015)

	Аюулгүй хог хаягдал (м ³)	Аюултай хог хаягдал (м ³)	Нийт хог хаягдал (м ³)	Бодит төлбөр (сая.төг)	Дахин боловсруулсан аюултай хаягдал (м ³)	Аюултай хог хаягдлыг булшлах (м ³)	Экспортолсон аюултай хог хаягдал (м ³)
2017	39,880.1	3,232.7	43,112.8	318.5	1,780.4	802.9	484.0

- Монгол дахь хог хаягдлын зохицуулалт

- Бүрхүүл болон хаягдал чулуулгийг ихэвчлэн хаядаг бөгөөд илүүдлийг бульдозероор түрж, өнцөгт налуу үүсгэдэг.
- Шингэн болон бусад хортой хог хаягдлыг уурхайн талбайн ойролцоох даланд хадгалдаг.
- Эрдэнэт үйлдвэрийн илүүдэл болон хаягдал чулуулаг жилд 10-12 сая тонноор нэмэгддэг.
- Оюу толгой нь хаягдлыг нягтруулан, хаягдал усыг дахин ашиглаж, хог хаягдлыг далан дотор байрлуулдаг.

4.1. Уул уурхайн салбарын нийлүүлэлтийн сүлжээ ба байгаль орчин

- Усны хэрэглээ

- 2017 оны байдлаар Монголын уул уурхайн компаниуд 68.2 сая шоо метр ус ашигласан нь гэрээнд заасан хэмжээний 92.5%-тай тэнцүү.

	Гэрээнд заасан усны хэрэглээ (м ³)	Гадаргын усны хэрэглээ (м ³)	Гүний усны хэрэглээ (м ³)	Усны нийт хэрэглээ (м ³)	Саарал усны дахин ашиглалт (м ³)
2017	73,695,603.4	8,003,409.5	60,179,913.9	68,183,323.3	3,408,628.6

- Уул уурхайн компаниуд ус бохирдуулсны төлбөр төлөх үүрэгтэй.
 - 2017 онд, уул уурхайн компаниуд ус бохирдуулсны төлбөрт 773 сая.төг төлсөн. Энэ нь нийт төсвийн орлогын 0.73%-тай тэнцүү.
 - Оюу Толгой нь усыг хамгийн үр ашигтай зарцуулдаг бөгөөд ашиглагдаж буй усны 85 гаруй хувийг дахин боловсруулдаг.
 - Нэг тонн хүдэр боловсруулахад 0.42 куб метр ус зарцуулдаг. Энэ нь дэлхийн дундаж болох 1.2 куб метрээс бага байна.

4.1. Уул уурхайн салбарын нийлүүлэлтийн сүлжээ ба байгаль орчин

- Уурхайн хаалт
 - Монгол Улсын тулгамдсан асуудал
 - Монгол Улсад уул уурхайн хаалтын дундаж гүйцэтгэл 30 орчим хувьтай байна.
 - 2015 оны байдлаар, 15 аймгийн 56 суманд байрлах 566 уурхайд ямар ч хаалт, нөхөн сэргээлт хийгдээгүй (Байгаль орчин аялал жуулчлалын яам)
 - Ж нь: Налайхын нүүрсний уурхай
 - Уурхайн хаалтын журам
 - Уурхайг түр болон бүр мөсөн хаах журам (2003) - Зөвхөн ерөнхий чиглэл өгөх боловч тодорхой заагаагүй.
 - Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “ашигт малтмалын хоёрдогч ашиглалтын эрх зүйн орчныг бүрдүүлж, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэх” үйл ажиллагааг тусгасан.
 - Гэхдээ одоогоор уул уурхайн хаалтын талаар шинэ журам, хуулийн төсөл батлагдаагүй байна.

4.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ) - байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хэмжихэд түгээмэл ашигладаг.
- Монгол Улсад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 2011 онд баталж, 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.
 - Ашигт малтмалын бүх төслүүдэд БОНБҮ заавал байх ёстой.
 - Байгаль орчны стратегийн үнэлгээ
 - Байгаль орчны төлөв байдал
 - Хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
- БОНБҮ болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй холбоотой журмуудыг Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нарийвчлан заасан байдаг.
 - Хэрэгжилт, ил тод байдал хангалтгүй байна.

5. Засаглал

5.1. Засгийн газрын оролцоо

- Уул уурхайн салбар дахь төрийн оролцоог Ашигт малтмалын тухай хуулиар голчлон зохицуулдаг.
- Ашигт малтмалын тухай хууль (2006)
 - Стратегийн ач холбогдол бүхий ордууд (ДНБ-ний 5 ба түүнээс дээш хувь)
 - Хайгуулыг улсаас санхүүжүүлэхгүй бол 34 хүртэлх хувийг Засгийн газар эзэмшинэ.
 - Хайгуулыг улсаас санхүүжүүлсэн тохиолдолд 50 хүртэлх хувийг Засгийн газар эзэмшинэ.
 - Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд
 - Ердийн ашигт малтмалын орд
- Бүх уул уурхайн компаниуд Монгол Улсад бүртгэлтэй байх, татвар төлөгчөөр бүртгэгдсэн байх ёстой бөгөөд Монгол Улсын хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулах ёстой.
 - Компанийн хувьцааны 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалах ёстой.

5.2. Хөрөнгө оруулалт

- Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулдаг.
- Хуулийн дагуу аж ахуйн нэгжүүд Тогтворжуулалтын гэрээний гэрчилгээ авч болно.
 - Гэрчилгээний үргэлжлэх хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тогтмол байна.
- Монгол Улсад 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй аливаа аж ахуйн нэгж ЗГ-тай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжтой.
- Засгийн газрын 52-р, 255-р тогтоолд:
 - Гэрээ байгуулах талаар тодорхой загвар байхгүй- Гэрээний агуулгын ерөнхий тоймыг дурдсан
 - Хэлэлцээр нь олон нийтэд нээлттэй биш
 - Олон нийтийн оролцоо, зохицуулалт хүндрэлтэй
 - Одоо хүчингүй болсон Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу хэд хэдэн хуучин тогтворжуулах гэрээ байгуулагдсан.
 - Одоогийн байдлаар зөвхөн Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ ил тод байгаа.

5.3. Маргаан шийдвэрлэлт

- Монгол дахь арбитрын ажиллагааг Арбитрын тухай хуулиар зохицуулдаг (2003 онд баталж, 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Арбитрын шүүх - зөрчлийг шийдвэрлэх хамгийн хурдан бөгөөд зардал багатай арга
 - Ихэнх арбитрын шүүх тодорхой асуудлаар мэргэшсэн байдаг – Энэ нь зөрчлийг өмнөх туршлага дээр үндэслэн шийдвэрлэх боломж олгодог.
- Компаниуд хөрөнгө оруулалтын гэрээндээ арбитрын ажиллагааны заалт оруулж болно.
- Монгол Улсын хуулийн байгууллагуудаас болгоомжилдог хөрөнгө оруулагчдад баталгаа болдог.

5.4. Авлигатай тэмцэх

- Байгалийн баялгаас олох орлогыг хуваарилах, удирдахад тулгардаг томоохон асуудал бол авлига юм.
- Уул уурхайн салбарыг **авлигад өртөмтгий** болгож буй гол шалтгаанууд:
 - Их хэмжээний хөрөнгө оруулалтын зардал
 - Өргөн цар хүрээтэй зохицуулалт
 - Тогтмол байршил (Fixed location)
- Transparency International байгууллагын тайланд (2017) дурдсанаар бүх улс оронд **уул уурхайн зөвшөөрөлтэй холбоотой авлигын эрсдэл байдаг.**
- Монгол Улсын авлигын эсрэг авсан арга хэмжээ
 - **Хууль эрх зүйн орчин**- Авлигын эсрэг хууль (2006)- Авлигатай тэмцэх газар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012)
 - **Ил тод байдлыг нэмэгдүүлэх**- Шилэн дансны тухай хууль (2014), ОУИТБС (EITI) (2010)

5.5. Хайгуул ба ашиглалт

- Тусгай зөвшөөрөл
 - Эхлээд хуулийн этгээд хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл авах ёстой.
 - Тусгай зөвшөөрлийг тендерийн журмаар авдаг.
 - Боломжит газрыг Ашигт малтмал, газрын тосны газраас ИТХ-ын зөвшөөрлийн дагуу шийдвэрлэдэг.
 - Орон нутгийн засаг захиргаа нь газрын ашиглалтад хяналт тавьж, баталгаажуулдаг.
- Уул уурхайн компаниуд орон нутгийн засаг захиргаа, иргэдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулах ёстой.
 - Энэ нь байгаль орчныг хамгаалах, ажил эрхлэлт, дэд бүтцийн хөгжил, уурхайн нийт ашиглалтын асуудлыг хамарна.
- Мэдээлэл олж авах
 - ОУИТБС (2006)
 - Оролцогч талуудын ажлын хэсэг Засгийн газар, уул уурхайн компаниуд, олон нийтийн төлөөллөөс бүрдэнэ.
 - Уул уурхайн болон худалдан авалтын гэрээг олон нийтэд ил тод болгох тал дээр анхаарч ажилладаг.
 - Гэхдээ дээрх мэдээллийг ил тод мэдээлээгүй тохиолдолд эрх зүйн хариуцлага хүлээхгүй - уул уурхайн салбарт мэдээлэл олж авах боломж хомс байна

5.6. Үйл ажиллагаа явуулж буй уурхай

- Татвар
 - Уул уурхайн тусгай татвар байхгүй - Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар зохицуулагддаг
 - Хэрэгжүүлэхэд хялбар ойлгомжтой байдлыг хангах хэрэгтэй
 - Уул уурхайн татварын тусгай нөхцөл нь үр өгөөжийг нэмэгдүүлэх боловч хэрэгжүүлэхэд хэцүү бөгөөд хүн хүч ихээхэн шаардана.
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
 - Татвар ба АМНАТ-ын систем - ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон, зарсан, борлуулахаар илгээсэн бүх бүтээгдэхүүний борлуулалтын үнэд үндэслэн төлдөг.
 - Олон улсын жижиг үнэд суурилсан шатлалтай АМНАТ-ын систем
 - ЗГ нь стратегийн ач холбогдол бүхий орд газруудад нэмэлт АМНАТ (5% хүртэл) ногдуулж болно.

5.7. Уурхайн хаалт

- Анх хайгуулын тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахдаа компаниуд байгаль орчныг хамгаалах зардлын тооцоог тусгасан байх ёстой.
- Тусгай зөвшөөрөл авсны дараа аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж буй аймгийн Засаг даргатай зөвшилцсөний дараа байгаль орчны нарийвчилсан төлөвлөгөөгөө ирүүлэх ёстой.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид жил бүр байгаль орчныг хамгаалах зардалд зарцуулах хөрөнгийн 50%-ийг орон нутгийн засаг захиргаанд байршуулах ёстой.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээг Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд бүртгэдэг.
 - Нэмэлт хяналт тавихын тулд олон нийтэд ойлгоход хялбар, хүртээмжтэй байх

5.8. Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010)
 - Төсвийн сахилга батыг хангах тодорхой зорилго, зохицуулалтыг тусгасан.
 - Гэсэн хэдий ч олон удаа нэмэлт өөрчлөлт оруулсан.
 - Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэний дээд хязгаарыг олон удаа өөрчилсөн (2010 оны хуульд ДНБ-ий 40% байсан бол 2016 онд 60% болсон)
- Ирээдүйн өв сангийн тухай хууль (2016)
 - Монгол улс тогтвортой хөгжилд хөрөнгө оруулах хүсэлтэй байгааг харуулж байна.
 - Төлөвлөж буй сангууд нь Монгол Улсын түүхий эдийн экспортын төсөөлөлд үндэслэсэн
 - Хэт өөдрөг төсөөлөл (ялангуяа нүүрс) нь төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.
 - Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд тулгарч байгаа.

Дүгнэлт

- **Эдийн засаг:** Монгол Улсын экспортын ихэнх хэсгийг ашигт малтмалын түүхий эдийн экспорт бүрдүүлдэг. Эдгээр бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт нь засгийн газрын орлогыг хэлбэлзүүлдэг. Монгол Улс уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх, ялангуяа экспортыг төрөлжүүлэх тал дээр анхаарч, орлогын үр ашигтай менежментэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.
- **Нийгэм:** Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаас гадна "нийгмийн лиценз (social license)" авах нь чухал. Компаниуд уурхайн үйл ажиллагааг тасалдуулах, зогсоохтой холбоотой зардлаас зайлсхийхийн тулд орон нутаг, холбогдох оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоож, бэхжүүлэх шаардлагатай.
- **Байгаль орчин:** Ашигт малтмалын төслийн бүхий л үе шатанд одоо мөрдөгдөж байгаа байгаль орчны талаарх дүрэм, журмын хэрэгжилт хангалтгүй байна. Уурхайн хаалт хийгдэхгүй байгаа нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байна.
- **Засаглал:** Монгол Улсад сайн засаглалыг хөгжүүлэх хууль тогтоомж олон байдаг боловч хэрэгжүүлэх, дагаж мөрдөхтэй холбоотой асуудал тулгардаг бөгөөд ил тод байдал дутагдалтай байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.